



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/296

Хэрлэн сум

**Хонины цэцэг өвчнөөс
урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/164 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн 5 суманд малын гоц халдварт хонины цэцэг өвчин оношлогдсонтой холбогдуулан өвчлөл бүртгэгдсэн голомт, сэжигтэй бүсэд хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 7 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2.Яаралтай дархлаажуулалтыг чанартай зохион байгуулахыг сумын мал эмнэлгийн тасагт, ажлын явц, чанарт хяналт тавьж ажиллахыг тухайн сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ